

САНХҮҮГИЙН ХЯМРАЛЫН ДАРААХЬ ҮЕИЙН МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ БА ХЯТАД, МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Э.Наран**

Гол агуулга: 2009 онд, дэлхий даяараа эдийн засгийн хямралд өртөж, ялангуяа олон улсын зах зээл дээр уул уурхайн бүтээгдэхүүний үнэ хэлбэлзсэний улмаас Монголын эдийн засаг эхний хагас жилд буурч, сүүлийн хагас жилд сэргэх байдалтай болсон. Хятад улс Монголын хамгийн том худалдааны түнш ба хамгийн их хөрөнгө оруулагч улсын хувьд, Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагаанд нэлээд хүчтэй байдлаа хадгалсаар байна. Энэ өгүүлэлд Хямралын дараахь Монголын эдийн засаг, Монголын стратегийн орд ба гадаадынханы “шатрын тоглолт”, Хятад, Монголын эдийн засаг, худалдааны байдлын үндсэн дээр, уул уурхайн салбарт хамтран ажиллахдаа авах арга хэмжээний талаар хэдэн саналыг хоёр талд дэвшүүлээ.

Хямралын дараах үеийн Монголын эдийн засаг

2008 оны 4-р улиралд эхэлсэн дэлхийн санхүүгийн хямралын нөлөөгөөр, Монголын гадаад худалдааны экспортын хэмжээ огцом буурч, ажилгүйдлын хэмжээ өсч, мөнгөний ханш нэмэгдэж, гадаад валютын зах зээл их хэмжээтэй хэлбэлзэх зэрэг олон хүчин зүйл гарч, экспортыг голлон түшсэн Монголын эдийн засаг ноцтой цохилтод өртсөн юм.

2009 онд Монголын эдийн засаг, эхний хагас жилд буурч, сүүлийн хагаст сэргэв. Эхний хагас жилд Монголын импорт, экспортын нийт хэмжээ 1 тэрбум 656 сая америк доллар байсан нь түрүү оны мөн үетэй харьцуулбал 39,6%, экспортын хэмжээ 40% буурч, гадаад худалдааны хэмжээ ялангуяа экспортын хэмжээ нь ихээр буурч, бусад салбарын эдийн засгийн үзүүлэлт огцом унаж, эдийн засгийн байдал маш хүндэрчээ. Гэвч сүүлийн хагас жилд олон улсын зах зээл дээр зэс, алт, нүүрс, цайр зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний олон улсын үнэ дахин өсч Монголын экспортын худалдааны хэмжээ аажмаар өссөнөөр бүхий л эдийн засаг ч аажмаар сэргэжээ. 2009 онд Монголын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2 тэрбум 810 сая ам.доллар /2005 онтой харьцуулбал/ 1.6%-иар буурчээ.¹ Монголын дотоодын нийт бүтээгдэхүүнээс нэг хүнд 1537 ам.доллар ногдож байгаа /тухайн жилийн ханшаар/, инфляцийн түвшин 4.2%, бодит ажилгүйчүүдийн тоо 119 мянга хүрч, түрүү оныхоос 28% нэмэгджээ.

Монголын эдийн засагт сэргэх эхлэл гарч байна гэж хэлж болно. Монголын засгийн газрын үзэж байгаагаар, Монголын гадаад орчин эдийн засагт нэн ашигтай тусаж, хэрвээ уул уурхайн ашигт малтмалын үнэ үргэлжлэн өсвөл, 2010 онд эдийн засгийн өсөлт 7-8% нэмэгдэх бүрэн боломжтой, Монголын эдийн засаг 2010 оны сүүлийн хагаст нэлээд их өсөх магадлалтай аж.

* Э.Наран - Өвөр Монголын их сургууль, Монгол судлалын хүрээлэн, судлаач, доктор (Sc.D)

Монгол Улсын стратегийн орд газрууд ба гадаад орнуудын тоглолт

2008 оны эхээр, Монголын Парламентийн баталсан “Монгол Улсын цогц хөгжлийн төлөвлөгөө”-нд зааснаар, тус улсын стратегийн орд газруудыг нээж ашиглахыг түргэтгэх, эдийн засгийн үргэлжилсэн тогтвортой хөгжлийг хадгалах, эцсийн дүндээ уул уурхайн ашиг орлогыг иргэн бүрт ашигтай хүртээж, 2021 онд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 12-15 мянган ам.долларт хүрнэ. Ялангуяа олон улсын санхүүгийн хямралын сөрөг нөлөө Монголд хараахан арилаагүй байхад, уул уурхайг Монголын эдийн засгийг цаашид хөгжүүлэх шинэ хөдөлгөгч хүч болгохын тулд Монголын засгийн газар стратегийн ордуудаа нээж ашиглах алхмаа хурдасгалаа.

Монголын стратегийн гол орд ба гадаад орны “шатрын тоглолт”-ын байдлыг товч танилцуулъя.

1. Оюу Толгойн зэс, алтны уурхай.

Тус уурхай бол Монголын 15 стратегийн орд газрын нэг юм. 32 сая тонн зэс, 1200 тонн алтны нөөцтэй. Азийн хамгийн том зэсийн уурхай, дэлхийд 4-рт орно. Тус уурхай нь Өвөр Монголын харалдаа Өмнөговь аймагт Өвөр Монголын Ганц модны боомтоос ердөө 70 км-т оршдог.

2009 оны 10-р сарын 6-нд, Монголын засгийн газар Канадын Айвенхоу уул уурхайн компани, Австралийн уул уурхайн аж ахуйтай Оюу Толгойд хөрөнгө оруулж ашиглах хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Энэ төслийн нийт хөрөнгө оруулалт 4 тэрбум ам.долларт хүрнэ. Тус уурхайг нээж ашигласны дараа зэс ба алтны жилийн үйлдвэрлэлийн хэмжээ тус бүр 450 мянган тонн ба 330 мянган унц хүрч, жил бүр Монголын экспортыг 2-2.5 тэрбум ам.доллараар нэмэгдүүлнэ.

Одоо Хятад улс тус уурхайг нээж ашиглахад оролцох гэж хүчин чармайж байна. Хятадын хөнгөн цагааны /Лю юе/ корпораци үүнд оролцох, ашиглахыг хүсэж байна. Австралийн хэвлэлийн мэдээгээр² Монголд Хятадтай хамтран ажиллах дургүй хүн байна. Хэрэг дээрээ аль ч улс Монголд уурхай нээж ялангуяа Хятад, Монголын хилийн ойролцоо уурхай нээвэл, гол нь Хятад зах зээл нь болох ба түүнчлэн зам, тоног төхөөрөмж техник, ажиллах хүч, тэр ч байтугай ар талын баталгаа, ихээхэн хэмжээгээр Хятадад түшиглэх хэрэгтэй болно. Хятадын үйлдвэр аж ахуйн газрын оролцоогүй бол Хятад гэсэн том худалдан авагчаа алдаж, бас олон уурхайн бүтээгдэхүүн, борлуулалтын зэрэг асуудал гарна. Тэгвэл Монгол Улс өөрөө далайгаар гаргаж чадахгүй. Тус уурхай Хятад-Монголын хилээс ердөө хэдэн арван км зайтай байхад, Оросыг тойрон экспортлох нь эдийн засгийн хувьд илт тооцоогүй явдал юм. Иймээс тус уурхай эцсийн дүндээ Хятадтай ямар нэг хэлбэрээр хамтран ажиллахаас аргагүй юм.

2. Таван толгойн нүүрсний уурхай

Тус уурхай бол Монголын стратегийн томоохон ордын нэг, Өмнөговь аймагт, Хятадын Ганц модны боомтоос 190 км зайтай байдаг. Таван

толгойн нүүрсний уурхайн илрээд буй нөөц нь 6,4 тэрбум тонн, түүний дотор 1,8 тэрбум тонн нь коксжисон нүүрс. Дэлхийд эхний 10 байранд орох том уурхай.

Сүүлийн жилүүдэд олон улсын нэр хүнд бүхий зарим компаниуд Таван Толгойн нүүрсний уурхайг ашиглах эрхийг хайн хойно хойноосоо элдвээр хөөцөлдөж байна. Тус уурхайд өрсөлдөж буй компани дотор Хятад, Өмнөд Солонгос, Орос, Америк, Япон, Энэтхэг, Бразил, Казакстан зэрэг орны 20 гаруй компани байна.

Одоо Хятадын Шэнхуа корпораци Таван толгойн нүүрсний уурхайд өрсөлдөх ихээхэн давуу байдалтай байна.

1-рт, Шэнхуа корпораци бол Хятадын хамгийн том үйлдвэр аж ахуйн газар ба хамгийн том нүүрс ханган нийлүүлж борлуулах улсын үйлдвэрийн газар, тэргүүний тоног төхөөрөмж, технологитой.

2-рт, тус уурхай Хятадын хилээс нэлээд ойрхон, газар нутгийн хувьд давуу талтай.

3-рт, Хятад бол хамгийн том нүүрсний эрэлт хэрэгцээтэй зах зээлийн нэг. Монгол Улс гадаадтай хамтран ажиллах явцдаа хамгийн их ашиг олохыг хүсэж байгаа, мөн аль нэг улсыг дангаар түшиглэхийг хүсэхгүй байгааябусад улсаас эдийн засгийн аюулгүй байдалд заналхийлэл учруулахгүй байхыг хүсэж байна. Иймээс Монгол Улс хоёр буюу хэд хэдэн гадаадын компанитай хамтран тус уурхайг ашиглахыг хүсэж байна.

3. Гадаадынхан Монголын ураны уурхай дахь өрсөлдөөнт байдал

Монгол ураны уурхайн ашигт малтмалаар маш баялаг. Тус улсын стратегийн ордын дотор ураны уурхай 3 байна. Оросын хайгуулын хэмжилтээр Монголын ураны нөөц 1,3 сая орчим тонн,³ дэлхийд эхний 15-р байранд орж байна. Дэлхийн цөмийн эрчим хүчний хурдацтай хөгжлийг дагалдаад холбогдох бүхий л орон Монголтой ураны баялгийг хамтран нээж ашиглах саналтай байна. Орос, Франц, Япон, Хятад, Өмнөд Солонгос, Америк зэрэг улсууд Монголын ураны уурхайг маш их сонирхож байна. Монгол Улс баялаг уурхайн ашигт малтмалд хандахдаа, бодит хүчин чадал бүхий улстай хамтран ураны уурхайг нээж ашиглах, улмаар бага оврын цөмийн цахилгаан станц байгуулахаар төлөвлөж байна.

Хятад: 2008 оны 12-р сард Монголын ерөнхийлөгч Н.Энхбаяр Бээжинд Хятадын цөмийн эрчим хүчний корпорацийн ерөнхий захирал Кан Рисинь-тэй уулзахдаа Монгол Улс Хятадтай цөмийн эрчим хүчний салбарт, хамтын ажиллагаагаа зузаатгах, хүн сургаж бэлтгэх талаар хамтран ажиллахыг хүсэж байгаагаа илэрхийлсэн юм. 2009 оны 3-р сард Монголын засгийн газрын цөмийн эрчим хүчний газрын дарга С.Энхбат Монгол Улс Хятадын 300 MW ангиллын бага оврын цөмийн цахилгаан станцын техник технологийг ашиглахыг хүсэж буйгаа илэрхийлжээ.

Япон: 2009 оны 7-р сард, Монголын Ерөнхий сайд С.Баяр Японд айлчлах үедээ, хоёр тал Монголын ураны баялгийг нээж ашиглах хамтын

ажиллагааг зузаатгахаар санал нэгтэй байгааг тэмдэглэв. Японы Ерөнхий сайд Наота Кам-тай ярилцах үедээ Монгол Улс Японы үйлдвэр аж ахуйн газрынханыг Монголын уул уурхай зэрэг уул уурхайн ашигт малтмалыг нээж ашиглахад идэвхтэй оролцохыг хүсэж байгааг хэлсэн юм. Уулзалтын дараа, хоёр тал цөмийн эрчим хүчний салбарт хамтын ажиллагаагаа зузаатгах тухай санамж бичигт гарын үсэг зурсан юм. Хүн сургаж бэлтгэх талаар, Япон улс Монголд цөмийн эрчим хүчний мэргэжилтэн бэлтгэх, хоёр орон судлаачдыг тодорхой хугацаагаар солилцох механизм бий болгохоор тогтов.

Орос улс: 2008 оны 4-р сард, Монгол-Оросын Энх тайвны зорилгоор ашиглах цөмийн эрчим хүчний хамтын ажиллагааны хамтарсан ажлын төлөвлөгөөнд гарын үсэг зурав. 2009 оны 1-р сард хоёр тал Монголын Дорнод аймгийн Мардайн ураны уурхайг хамтран ашиглахаа хэлэлцэн тохиров. 2009 оны 3-р сард Монголын Ерөнхий сайд С.Баяр Орост айлчлахдаа боловсон хүчин бэлтгэх хэлэлцээнд гарын үсэг зурж, Оросын тал жил бүр ураны уурхайн хайгуул хийх, нээж ашиглах тусгай мэргэжлийн 15-аас доошгүй хүнийг бэлтгэхээр тогтов. 2009 оны 5-р сард Оросын Ерөнхий сайд В.Путин Монголд айлчлах үедээ, Орос-Монголын тал ураны уурхайг нээж ашиглах асуудлаар тохиролцоонд хүрсэн юм.

В.Путин үүнээс өмнө Японд айлчлахдаа Японы талтай ураны уурхайг нээж ашиглах хамтын ажиллагааны хэлэлцээ хийж, улмаар Оросын тал Японтой хамтран Оросын умард нутгийн Якутын ураны уурхайг нээж ашиглахаар шийдвэрлэсэн юм. Түүнчлэн гуравдагч улсад, тухайлбал Монголд ураныг нээж ашиглахаар болжээ.

Хятад, Монголын эдийн засгийн харилцаа

1. Хоёр талын худалдаа

Монголын Статистикийн газрын мэдээгээр, 2009 онд Хятад, Монголын худалдааны импорт экспортын нийт хэмжээ 1 тэрбум 914 сая 340 мянган америк долларт хүрч, түрүү оныхоос 24,5%⁴ буурчээ. Хоёр орны худалдаа Монголын гадаад худалдааны 47,5% болж байна. Түүний дотор Монголын Хятадад хийсэн экспорт 1 тэрбум 389 сая ам.долларт хүрч, Монголын экспортын нийт хэмжээний 73%-ийг эзэлж, Хятадаас Монголд импортлосон бараа 525 сая ам.доллар болж, Монголын импортын 24,63%-ийг эзэлж байна. Хятад бол Монголын нэгдэх том худалдааны түнш, нэгдэх том экспортлогч орон юм.

2. Хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа

2009 оны эцсээр, Хятадаас Монголд оруулсан хөрөнгө оруулалт 2 тэрбум 290 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын объект нь гадаадаас Монголд оруулж буй хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын объектын 50-аас дээш хувийг эзэлж байна. Хятад улс 12 жил дараалан Монголд хамгийн том хөрөнгө оруулагчийн байр сууриа хадгалж байна.

Гэвч Хятадаас Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын хэрэгцээ тасралтгүй өөрчлөгдөж байна. Төмөртийн овооны цайрын уурхайнаас бусад Монгол Хятадын хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр сайн нэр

төдий л үгүй байна. Хятадын хөрөнгө оруулалттай үйлдвэр Монголд аж ахуй эрхлэх хугацаандаа байгаль орчны хамгаалалт муу хийж, татвар бага өгч, техник технологийн ашиглалт доогуур, үр бүтээл хангалтгүй байна гэж Монголын тал үзэж байна.

Хятад, Монголын уул уурхайн хамтын ажиллагааны хэтийн төлөв

Одоо, Хятад Монголын харилцаа түүхийн хамгийн сайн үедээ байна. Урт хугацааны, тогтвортой, үр ашигтай эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа бол хоёр орны төрийн харилцаа гүнзгийрэн хөгжих материаллаг үндэс суурь юм. Хоёр талын эдийн засаг худалдааны харилцааг үргэлжлэн хөгжихийг ахиулахын тулд, хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа, ялангуяа уул уурхайн салбарын хамтын ажиллагааны хязгаарлах хүчин зүйлийг тооцон дүн шинжилгээ хийх, энэ үндсэн дээр цаашдын хөгжлийн хандлагыг тодорхойлох хэрэгтэй.

Хятадын тухайд: 1. Монголд байгаа Хятадын олон үйлдвэр, аж ахуйн газар Монголын зах зээл, хууль журам, бодлогыг сайтар ойлгохгүй, төслийн эхэн үеийн боломжит судалгаа хангалтгүй, аюул эрсдэлийг дутуу тооцдог. 2. Хятадын талын үйлдвэр аж ахуйн газрууд гадаад улсад эмх замбараагүй өрсөлдөн, дүрэм журамгүй ажиллах нь хоёр талын хамтын ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Монголын тухайд: 1. Монголын бодлого нь их хувирч өөрчлөгддөг, итгэхэд хэцүү. 2. Монголын дэд бүтэц хоцрогдсон, их хэмжээний урьдчилсан хөрөнгө оруулалт шаардлагатай. 3. Эдийн засгийн бус дутагдаж буй итгэлцлийн хүчин зүйл бол анхаарахгүй байж болохгүй саад бэрхшээл юм.

Олон улсын тухайд: Хэдийгээр Хятад нь Монголын хамгийн том гадаад худалдааны түнш, хамгийн их хөрөнгө оруулагч улс боловч Орос улс ерөөсөө Монголын хамгийн том импортлогч улс байдаг. Өнөөг хүртэл Монголын бүхий л хэрэгцээт шатахууны 95-аас дээш хувийг мөн баруун аймгуудын цахилгаан эрчим хүчийг бүхэлд нь Оросын тал нийлүүлдэг. Үүний зэрэгцээ Монголын хөрсөн дээрх ба газар доорх ашигт малтмалын баялаг Япон, Канад, Австрали, Америк зэрэг бусад улсуудыг маш ихээр татаж, тэд нар Монголтой улс төр, эдийн засаг, тэр ч байтугай цэргийн харилцаатай байхыг шамдан чармайж, Монголын зах зээл ба уул уурхайн баялагт өрсөлдөж байна.

Монгол Улс бас өөрийн арвин баялаг ашигт малтмалын давуу байдалдаа найдаж, дотоод бодлого, гадаад бодлогодоо байнга зохицуулалт хийж, олон улс орны хооронд тэнцвэртэй байдал хайж, ихээхэн ашиг олохоор чармайж байна.

Санал

1-рт, Хятад, Монголын хооронд итгэлцлийн эргэлзээг тайлах, харилцан итгэлцлийг, ялангуяа хоёр орны иргэд хоорондын харилцан

итгэлцлийг нэмэгдүүлэх, Монголын тал холбогдох хууль эрхээ бүрэн сайжруулж, түүний тогтвортой байдал, залгамж чанарыг баталгаатай болгох, Хятадын тал хүн хүчин бэлтгэх ба гадаадад ажиллах хүчин илгээх ажлаа чангатгаж, тэдний техникийн түвшин, хэлний чадвар хийгээд ерөнхий дадлага боловсролыг дээшлүүлэх хэрэгтэй байна.

2-рт, Хятад Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа хоёр талынхаас олон талынх болж өргөжих ёстой. Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалтын өрсөлдөөнт байдал доор Хятад, Оросын стратегийн түншлэлийн харилцаа ба Орос, Монголын стратегийн түншлэлийн харилцааг ашиглан, 3 тал хамтран Монголын дэд бүтцийн бүтээн байгуулалт ба уул уурхайн баялгийг нээж ашиглахад оролцож болох юм. Хятад улс Монголын эдийн засаг худалдааг 2 талынхаас олон талт хамтын ажиллагаа болгон өргөжүүлж, улмаар бүс нутгийн хамтын ажиллагааг явуулж болно. Хятад улс нээлттэй бодлого баримталж, Монголын ашигт малтмалын зах зээл дээр, олон орны амжилттай туршлага, өндөр шинэ технологи нэвтрүүлэх, тэгш өрсөлдөх, хамтран ажиллахаар хичээн чармайна. Түүнчлэн ийм олон талын хамтын ажиллагааны арга хэлбэр ба үзэгдэхүйц нэлээд өндөр нийтийн тавцанг Монгол Улс хүлээн авснаар Монголын тал аль нэгэн улсыг түшиглэх явдалд санаа зовохоо багасгах болно.

3-рт, Хүнийг гол болгож, тухайн газрын орчинг хамгаалахыг чухалчлах. Хятад улс Монголын эдийн засгийн үйл ажиллагаанд, Монгол Улсын олон нийтийн эрхэмлэдэг байгалийн ёс заншлыг хүндэтгэж, цаашид байгаль орчинг хамгаалах асуудлыг тэргүүн байранд тавьж, уул уурхайн районыг ногооруулах, экологийг сэргээх, тухайн нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах ажлыг хийх хэрэгтэй.

Үүнээс гадна Монгол Улс бол Хятадын умарт хөрш бөгөөд хүрээлэн буй орчны сайн муу байх нь Монголд нөлөөлөөд зогсохгүй, Хятад ба Зүүн хойт Азийн бүс нутгийн экологийн аюулгүй байдалд ч шууд нөлөөтэй юм.

ЭШЛЭЛ ЗҮҮЛТ

1. Монгол Улсын статистикийн газар: “2009 оны Монгол Улсын эдийн засаг нийгмийн статистикийн урьдчилсан мэдээ” 2010 оны 1-р сарын 14-ны өдөр нийтлэв.
2. Монголчууд Хятадад хандахдаа сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулж чадаагүй. “Хуанчю Шибao” 2009.11.2
3. “Оросын хэвлэл: Монголын ашигт малтмалыг Америк онилж байна. “Ураны хувьсгал хийе” “Хуанчю Шибao” 2008.7.3
4. Монголын Гаалийн ерөнхий газрын “Монголын гадаад худалдааны албан мэдээ”-ний 2009 оны 12-р хугацааны тоо баримтаас.

Хятад хэлнээс орчуулсан /Л.Бэгзжав